2.2. Албан хаагчийг сонгон шалгаруулах журам

| № | Эрхзүйн баримт бичиг | Хэрэгжилт |
|---|---|---|
| 1 | Төрийн албаны зөвлөлийн тогтоол<br><br>2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Дугаар 14 ТӨРИЙН АЛБАНЫ ТУСГАЙ ШАЛГАЛТ ӨГӨХ БОЛЗОЛ, ЖУРАМ, ЗАГВАР БАТЛАХ ТУХАЙ:<br><br>Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.12, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:<br>1. "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Төрийн албаны тусгай шалгалтын нэгдсэн үнэлгээний хуудас"-ны загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.<br>2. Энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба, Салбар зөвлөлд тус тус даалгасугай.<br>3. Энэ журам батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн "Заавар батлах тухай" 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.<br><br>ДАРГА Б.БААТАРЗОРИГ | Үндэсний геологийн алба албан хаагчийг сонгон шалгаруулахдаа Төрийн албаны зөвлөлийн баталсан тогтоолоор батлагдсан журмын дагуу сонгон шалгаруулж ажилладаг. |